

АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 2046.9 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 2.2 дахин давж биелсэн байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс 971.4 сая төгрөгөөр дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 10.8 хувиар тасарсан байна. Үүнд: Дарьганга 56.7 хувь, Баруун-Урт 42.1 хувь, Мөнххаан 1.4 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн зарлага санхүүжилт 963.8 сая төгрөг болж, төлөвлөгдсөн хэмжээнээс 16.8 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Эхний улирлын байдлаар 89.6 сая төгрөгийн төсвийн хөрөнгө оруулалт хийгдсний 74.3 сая төгрөг нь төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын нийгмийн даатгалын салбарт, 15.3 сая төгрөг нь эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт тус тус оржээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас банкнаас аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 12.7 тэрбум төгрөгт хүрсэн нь 2009 оны жилийн эцсээс 309.4 сая төгрөгөөр буурсан байна. Жич: Шуудан банк, хадгаламж банктэй нэгдэж, хадгаламж банк нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхлэв.

Банкуудад хадгалуулсан иргэдийн хадгаламжийн хэмжээ 8.5 тэрбум төгрөг болсон нь 2009 оны жилийн эцсээс 1.1 тэрбум төгрөгөөр өссөн байна. Мөн банкуудын хугацаа хэтэрсэн зээл 0.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Мал аж ахуй: Оны эхний төллөх эх малын 9.3 хувь болох 71.7 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.1 хувь болох 71.3 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Оны эхний малын 0.7 хувь болох 11.4 мянган мал зүй бусаар хорогдсон нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.9 дахин буюу 8.5 мянгаар дээгүүр байна.

Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Мөнххаан, Асгат сумдад оны эхний малын 4.3 - 0.6 хувь нь зүй бусаар хорогдсон нь хамгийн их байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 8.2 тэрбум төгрөг болж урьд оны мөн үеийнхээс 0.5 тэрбум төгрөгөөр дээгүүр байна.

Оны үнээр 35.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн нь урьд оны мөн үеийнхээс 7.1 дахин дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлийн талх, нарийн боов, нүүрс, цайрын баяжмал, дулаан үйлдвэрлэлт урьд оны мөн үеэс дээгүүр үзүүлэлттэй байна.

V. ТЭЭВЭР, ХОЛБОО: Барилга: Тээвэр: Тээвэр бүхий байгууллагууд 12930.2 мян.тн.км-ийн ачаа эргэлт, 5952.0 мян.хүн.км-ийн зорчигч эргэлт хийж гүйцэтгэн 1.3 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ.

Холбоо: Холбоо ашиглалтын орлого 58.9 сая төгрөг байгаагийн дотор 31.6 сая төгрөг нь хүн амаас орсон байна. Телефон цэгийн тоо 1043 болж урьд оны мөн үеэс 44.3 хувиар буурсан байна.

VI. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: Хэрэглээний үнийн индекс 3-р сард өмнөх 2009 оны жилийн эцсийнхээс 6.2 хувиар өслөө.

Энэхүү өсөлтийн цаана Хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 13.0 хувиар, түүн дотроо хүнсний бараа 13.4 хувь, үүнээс мах махан бүтээгдэхүүний үнэ 38.1 хувиар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 18.0 хувь, жимс, жимсгэнэ 28 хувь, хүнсний ногоо 39 хувь, хүнсний бусад бүтээгдэхүүн 7.6 хувиар тус тус өссөн байна.

Тээврээс бусад бүлгийн үнэ өссөний дотор Холбооны үнэ, тариф 31.3 хувиар өсч, Боловсрол, нийтийн хоол, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны бүлэг, орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад үнэ, тариф тогтвортой байлаа.

VII. ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ: Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2.6 тэрбум төгрөг болж төлөвлөгөөгөө биелүүлжээ. Сайн дурын даатгуулагчид 13.8 сая төгрөгний шимтгэл оруулсан боловч, төлөвлөгөө нь 66.2 хувиар тасарсан байна. 6171 өндөр настанд 1543.3 сая төгрөгийн тэтгэвэр олгохоос бүрэн олгосон байна. Нийгмийн халамжийн сангаас 309.9 сая, хүүхэд хөгжил сангаас 1730.1 сая, улсын төсвөөс 285.7 сая, нөхөн олговроор 243.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

VIII. ЭРҮҮЛ МЭНД: Эхний 3 сард 297 эх амаржсан нь өнгөрсөн оны мөн үеэс 16 эхээр олон байна. 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 9 байгаа нь урьд оны мөн үеэс олон байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 133 болж урьд оны мөн үеэс Цусан суулга өвчнөөр өвчлөгчдийн тоо өсч, бусад халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо буурсан байна.

IX. АЖИЛГҮЙЧҮҮД: Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1163 болж, урьд оны мөн үеийнхээс 195 хүнээр нэмэгдсэн байна. Ажилгүйчүүдийн 66.9 хувь нь 16-34 насны залуучууд, 18.3 хувь нь дээд, 4.6 хувь нь тусгай дунд, 37.1 хувь нь бүрэн дунд, 7.6 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

296 хүн шинээр бүртгүүлж, 155 хүн ажилд орсон байна.

Шинэ ажлын байранд ажиллаж байгаа хүний тоо 55 хүрчээ.

X. ГЭМТ ХЭРЭГ: Эхний 3 сард 46 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны 6-аар доогуур байна.

Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 13 хүн гэмтэж, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд 11.7 сая төгрөгийн хохирол учирсны 10.0 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 39 хүн холбогдон сэжиглэгдсэний 20.5 хувь нь согтуугаар, 20.5 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлдсэн байна.

Нийт 485 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеийнхээс 116 хүнээр цөөн байна. Нийт эрүүлжигдсэн хүмүүсээс 32 хүн баривчлагдаж захиргааны арга хэмжээ авхуулсан байна.

Хэрэг илрүүлэлт 93.1 хувьтай байна.

XI. ДААТГАЛ: Малын индексжүүлсэн даатгал төслийн хүрээнд 13 суманд 4 даатгалын нэгжийн 71 төлөөлөгч ажиллаж эхлээд байна.

2010 оны эхний 3 сарын байдлаар малын индексжүүлсэн даатгал хийгдээгүй байна.

Даатгалын салбарууд: Даатгалын байгууллагуудын хураамжын орлого 8.2 сая төгрөг орж, төлөвлөгөө нь 47.6 хувиар тасарсан байна. 122 хүнд 8.8 сая төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Үүнээс авто тээврийн хэрэгсэлд 5.2 сая, гэнэтийн осолд 2 сая, хөдөлмөрийн чадвар түр алдалт 1.3 сая, хүүхдийн гэнэтийн осолд 0.2 сая, иргэдийн эд хөрөнгө 0.1 сая төгрөгийг тус тус олгожээ.

XII. ТӨСЛҮҮДИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ: ЖДҮДТөсөл: 2009 онд жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төслөөр нийтдээ 776.0 сая төгрөгийг 54 төслийг дэмжиж өгсөн байна.

2010 онд 4 сумын нийт 15 төсөл ирж, эхний шатны шалгаруулалтаар 10 төсөл дэмжигдэж арилжааны банкуудад хүргэгдээд байна.

ХЭДСан: Аймгийн хэмжээгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 100.6 сая төгрөгийн зээл олгож, 116 хүний ажлын байрыг бий болгосон байна. Дарьганга 17.4 сая, Сүхбаатар 16.3 сая төгрөгийн зээл олгосон нь бусад сумдын зээл олголтоос дээгүүр үзүүлэлттэй байна.

ТА-2 төсөл: Тогтвортой амжиргаа II төслийн хүрээнд аймгийн хэмжээгээр 38.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тохижуулалтанд 25.8 сая, засварын ажилд 4.2 сая, тоног төхөөрөмж худалдан авахад 1.2 сая төгрөгийг тус тус зарцуулжээ.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС